



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БӨА-2022/58/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Ж.Назгүл Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**БУЯНТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ М.ХАНДСҮРЭН  
ТАНАА**

᠒᠐᠒᠒ . ᠐᠒ . ᠒3 № 1᠒5  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>13,403,643.95</u></b>	<b><u>64,346,941.75</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	42,322,500.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		42,322,500.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	13,403,643.95	22,024,441.75
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	5,006,185.00	12,692,104.00
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал	5,006,185.00	12,692,104.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	8,397,458.95	9,332,337.75
35410	Бичиг хэргийн материал	1,018,788.00	1,018,788.00
35420	Аж ахуйн материал	2,266,185.00	2,266,185.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	898,639.31	378,699.31
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал	4,213,846.64	5,668,665.44
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>236,029,971.70</u></b>	<b><u>422,982,855.00</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	236,029,971.70	422,982,855.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	230,997,971.70	417,950,855.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	211,417,830.00	352,772,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(28,908,425.84)	(36,539,128.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	51,317,511.00	91,317,511.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(32,509,833.38)	(42,183,682.70)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,954,419.09	98,221,649.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,214,440.00)	(47,120,106.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,004,847.84	37,104,847.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,063,937.01)	(35,622,834.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	128,000.00	128,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(128,000.00)	(128,000.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	5,032,000.00	5,032,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	550,000.00	550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,032,000.00	5,032,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>249,433,615.65</u></b>	<b><u>487,329,796.75</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>-</u></b>	<b><u>21,608,179.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	21,608,179.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	21,608,179.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	21,608,179.00
41361	Байгууллагад төлөх өглөг		21,608,179.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>249,433,615.65</u></b>	<b><u>465,721,617.75</u></b>

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	249,433,615.65	465,721,617.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	263,882,593.00	263,882,593.00
51101	Өмч: - төрийн	263,882,593.00	263,882,593.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(97,483,217.23)	118,804,784.87
51210	Өмнөх үеийн үр дүн	(97,483,217.23)	(97,483,217.23)
51220	Тайлант үеийн үр дүн		216,288,002.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	83,034,239.88	83,034,239.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>249,433,615.65</u></b>	<b><u>487,329,796.75</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>422,882,116.00</b>	<b>721,256,536.23</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>28,152,397.00</b>	<b>17,712,395.24</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	28,152,397.00	17,712,395.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,152,397.00	17,712,395.24
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,152,397.00	17,712,395.24
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>394,729,719.00</b>	<b>703,544,140.99</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	335,689,800.00	570,072,699.99
131005	Хөрөнгийн санхүүжилт		212,871,999.99
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	335,689,800.00	357,200,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	13,591,009.00	56,030,541.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,591,009.00	56,030,541.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	22,758,800.00	13,535,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,758,800.00	13,535,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	22,690,110.00	63,905,000.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,690,110.00	63,905,000.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>410,856,541.91</b>	<b>504,968,534.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>410,856,541.91</b>	<b>504,968,534.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	410,856,541.91	475,568,534.13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	255,272,023.00	292,500,773.00
210101	Үндсэн цалин	175,739,898.00	185,857,961.00
210102	Нэмэгдэл	62,939,221.00	75,421,612.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		5,292,000.00
210104	Урамшуулал	16,592,904.00	25,929,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,892,200.00	39,351,220.00
210201	Тэтгэврийн даатгал	23,850,100.00	28,196,820.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,510,500.00	2,788,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,008,400.00	2,230,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	502,100.00	557,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,021,100.00	5,577,200.00

210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,922,795.00	13,323,840.00
210301	Гэрэл, цахилгаан	925,720.00	1,008,200.00
210302	Түлш, халаалт	20,997,075.00	12,315,640.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	36,280,030.00	37,244,047.00
210401	Бичиг хэрэг	1,309,700.00	1,440,900.00
210402	Тээвэр, шатахуун	32,124,730.00	31,684,847.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,561,700.00	1,851,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,283,900.00	2,266,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	35,217,274.70	58,284,706.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,633,235.00	49,488,225.24
210502	Хоол, хүнс	4,698,139.70	5,646,181.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,885,900.00	3,150,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,427,480.00	1,526,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,450,800.00	916,400.00
210604	Урсгал засвар	976,680.00	610,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,866,100.00	2,482,831.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,866,100.00	2,482,831.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	461,600.00	585,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,800.00	17,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,600.00	44,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.00	19,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	67,400.00	67,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	76,800.00	76,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	23,517,039.21	30,269,116.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,793,500.00	2,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,723,539.21	27,769,116.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	29,400,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	29,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		29,400,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>12,025,574.09</b>	<b>216,288,002.10</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>12,025,574.09</b>	<b>216,288,002.10</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,882,593.00	83,034,239.88	(97,483,217.23)		249,433,615.65
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	263,882,593.00	83,034,239.88	(97,483,217.23)		249,433,615.65
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн					-
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,882,593.00	83,034,239.88	(97,483,217.23)		249,433,615.65
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	263,882,593.00	83,034,239.88	(97,483,217.23)		249,433,615.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	263,882,593.00	83,034,239.88	(97,483,217.23)		249,433,615.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			216,288,002.10		216,288,002.10
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,882,593.00	83,034,239.88	118,804,784.87		465,721,617.75

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>394,729,719.00</b>	<b>448,349,641.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>394,729,719.00</b>	<b>448,349,641.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	335,689,800.00	357,200,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	335,689,800.00	357,200,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	13,591,009.00	56,030,541.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,591,009.00	56,030,541.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	22,758,800.00	13,535,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,758,800.00	13,535,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	22,690,110.00	21,582,500.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,690,110.00	21,582,500.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>387,955,719.00</b>	<b>446,499,641.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>387,955,719.00</b>	<b>446,499,641.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>387,955,719.00</b>	<b>417,099,641.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	255,272,023.00	292,500,773.00
210101	Үндсэн цалин	175,739,898.00	185,857,961.00
210102	Нэмэгдэл	62,939,221.00	75,421,612.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		5,292,000.00
210104	Урамшуулал	16,592,904.00	25,929,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,892,200.00	39,351,220.00
210201	Тэтгэврийн даатгал	23,850,100.00	28,196,820.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,510,500.00	2,788,600.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,008,400.00	2,230,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	502,100.00	557,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,021,100.00	5,577,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,782,120.00	12,803,900.00
210301	Гэрэл, цахилгаан	925,720.00	1,008,200.00
210302	Түлш, халаалт	20,856,400.00	11,795,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	36,253,230.00	34,846,117.00
210401	Бичиг хэрэг	1,282,900.00	1,440,900.00
210402	Тээвэр, шатахуун	32,124,730.00	29,286,917.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,561,700.00	1,851,800.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,283,900.00	2,266,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	32,207,466.00	30,502,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,532,221.00	20,251,500.00
210502	Хоол, хүнс	3,789,345.00	7,101,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,885,900.00	3,150,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,427,480.00	1,526,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,450,800.00	916,400.00
210604	Урсгал засвар	976,680.00	610,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,866,100.00	2,482,831.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,866,100.00	2,482,831.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	461,600.00	585,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,800.00	17,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,600.00	44,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.00	19,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	67,400.00	67,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	76,800.00	76,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,793,500.00	2,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,793,500.00	2,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>29,400,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	29,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		29,400,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>6,774,000.00</u></b>	<b><u>1,850,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,774,000.00</b>	<b>1,850,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,774,000.00</b>	<b>1,850,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	6,774,000.00	1,850,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,774,000.00	1,850,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(6,774,000.00)</u></b>	<b><u>(1,850,000.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>

8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	392,319,100.00	392,319,100.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	392,319,100.00	392,319,100.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	392,319,100.00	392,319,100.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	278,859,000.00	278,859,000.00
210101	Үндсэн цалин	172,861,500.00	172,861,500.00
210102	Нэмэгдэл	74,776,300.00	74,776,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,292,000.00	5,292,000.00
210104	Урамшуулал	25,929,200.00	25,929,200.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,646,000.00	37,646,000.00
210201	Тэтгэврийн даатгал	26,491,600.00	26,491,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,788,600.00	2,788,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,230,800.00	2,230,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	557,800.00	557,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,577,200.00	5,577,200.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,803,900.00	12,803,900.00
210301	Гэрэл, цахилгаан	1,008,200.00	1,008,200.00
210302	Түлш, халаалт	11,795,700.00	11,795,700.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,388,700.00	27,388,700.00
210401	Бичиг хэрэг	1,282,900.00	1,282,900.00
210402	Тээвэр, шатахуун	23,260,200.00	23,260,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,561,700.00	1,776,800.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,283,900.00	1,068,800.00
2105	<b>Нормативт зардал</b>	29,187,900.00	29,187,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,082,500.00	18,082,500.00
210502	Хоол, хүнс	7,101,000.00	7,101,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,004,400.00	4,004,400.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,348,000.00	2,348,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,616,000.00	1,616,000.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	732,000.00	732,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,000,000.00	1,000,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,000,000.00

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	585,600.00	585,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,800.00	17,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,600.00	44,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.00	19,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	67,400.00	67,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	76,800.00	76,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,500,000.00	2,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	392,319,100.00	392,319,100.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	357,200,700.00	357,200,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	357,200,700.00	357,200,700.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	13,535,900.00	13,535,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	13,535,900.00	13,535,900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	21,582,500.00	21,582,500.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,582,500.00	21,582,500.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	21.00	25.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	6.00
620004	Гэрээт ажилтан		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>21.00</b>	<b>25.00</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	17.00	19.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	6.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,591,009.00</b>	<b>56,030,541.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,591,009.00</b>	<b>56,030,541.00</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	13,591,009.00	26,630,541.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	4,338,998.00	13,641,773.00
210101	Үндсэн цалин	4,338,998.00	12,996,461.00
210102	Нэмэгдэл		645,312.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	1,705,220.00
210201	Тэтгэврийн даатгал		1,705,220.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	7,631,717.00
210401	Бичиг хэрэг		158,000.00
210402	Тээвэр, шатахуун		6,026,717.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,372,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,018,211.00	2,169,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,018,211.00	2,169,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,873,800.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,873,800.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	360,000.00	1,482,831.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	360,000.00	1,482,831.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	29,400,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	29,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		29,400,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	13,591,009.00	56,030,541.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	13,591,009.00	56,030,541.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,591,009.00	56,030,541.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Буянт сумын Эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тулгуурлан эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх замаар ирээдүйгээ бүтээнэ гэсэн зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ажилладаг бөгөөд тайлант онд тус байгууллагад шалгалт хийгдээгүй байна

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 410.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 237.8 сая төгрөгөөр буюу 95 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		42322.5	42322.5
Урьдчилгаа			
Бараа материал	13403.6	22024.1	8620.5
Үндсэн хөрөнгө	236029.9	422982.8	186952.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>249433.6</b>	<b>487329.8</b>	<b>237896.2</b>
Өр төлбөр		21608.2	21608.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	249433.6	465721.6	216288.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>249433.6</b>	<b>487329.8</b>	<b>237896.2</b>

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна. Авлага данс тайлант оны эцэст 42.3 сая болж өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу авсан санхүүжилт байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 22.0 сая төгрөг болж өмнөх оноос 8.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 117.9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 109.3 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 422.9 сая төгрөг болж 186.9 сая төгрөгөөр өссөн байна. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.5 сая төгрөгийн 2 ширхэг нотебүүк, 1 ширхэг принтер, Эрүүл мэндийн сайдын багцаас 40.0 сая төгрөгийн өртөгтэй УАЗ Hunter маркийн түргэн тусламжийн автомашин, Эрүүл мэндийн сайдын А/148, А/428, А/626, А/637, А/519, А/728 тушаалаар 11.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас 12.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, НҮБ-ын Хүн амын сангаас 4.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэгүй хүлээн авч, аймаг дахь Төрийн аудитын газрын албан шаардлагын дагуу 141.0 сая төгрөгийн барилгын их засварыг орлогод авч данс бүртгэлд тусгасан байна. Үндсэн хөрөнгөд 27.7 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Өглөг дансны үлдэгдэл 21.6 сая төгрөг болж өссөн нь 19.2 сая төгрөгийн эмийн, 2.4 сая төгрөгийн тээвэр шатахууны, нийт 21.6 сая төгрөгийн өглөгтэй гарсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 465.7 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 216.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 392.3 сая төгрөг ба тодотголоор төсөвт өөрчлөлт ороогүй байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 392.3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 392.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж үзэхэд төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй, харин өглөгтэй гарсан байна.

Нийт төсвийн 71 хувийг цалин, 9.6 хувийг НДШ-ийн зардал, 3.2 хувийг тогтмол зардал, 7.0 хувийг хангамж бараа материалын зардал, 7.4 хувийг норматив зардал, 0.6 хувийг урсгал засварын зардал, 0.1 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт дансаар 56.0 сая төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн яамнаас хүлээн авч 13.6 сая төгрөгийг цалингийн зардалд, 1.7 сая төгрөгийг НДШ-д, 7.6 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 2.2 сая төгрөгийг норматив зардалд, 1.5 сая төгрөгийг томилолтын зардалд, 29.0 сая төгрөгийг тэтгэмжийн зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан ба АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Буянт сумын Эргэлтийн эмийн санг хариуцаж байсан Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч нь сангийн хөрөнгийн тооцоо хийх, санхүүгийн тайлан гаргах боломжгүй байдлаас шалтгаалан сумын Засаг даргад 2021 оны 10 дугаар сард өргөдөл өгч сангийн тайлан гаргахаас татгалзсан байна.

Эргэлтийн эмийн санчийн ирүүлсэн задгай материалаас үзэхэд тайлант оны эхэнд 7.2 сая төгрөгийн эмийн үлдэгдэлтэй, 7.8 сая төгрөгийн орлогыг ХААН банкны 5185001347 тоот дансаар хүлээн авч 4.5 сая төгрөгийн зарлага гаргасан байна.

Эм ханган нийлүүлэх төвүүдээс Эрүүл мэндийн төвд ирүүлсэн тооцоогоор “Дэвшил баян фарм” ХХК-д 6.7 сая төгрөгийн, “Мөнхийн тун фарм” ХХК-д 1.1 сая төгрөгийн өглөгтэй байна.

Эргэлтийн эмийн сангийн тооцоо, санхүүгийн тайланг ирүүлээгүй тул санхүүгийн тайлангийн аудит хийх боломжгүй, АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Буянт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 6.1.2-т заасан Төсвийн гүйцэтгэл 3-р улирлын мэдээллийг "үгүй" гэж оруулсан, оны эцэст үүссэн 42.3 сая төгрөгийн авлага, 21.6 сая төгрөгийн өглөгийн мэдээллийг байршуулаагүй байна. Шилэн дансны хэрэгжилт 85 хувьтай байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудад нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар 20.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах 1 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн биелэлтийг Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 07 дугаар сарын 05 өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлжээ.

Гарсан зөрчлийг арилгаж байр ашиглалттай холбоотой гарсан тогтмол зардлын тооцоог өглөг дансанд бүртгэж тооцоо үүсгэж тайлагнасан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 63.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

### **4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

### **4.2 Төлбөрийн акт**

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

### **4.3 Албан шаардлага**

Албан шаардлага байхгүй

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Шилэн данстай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-т заасан Төсвийн гүйцэтгэл 3 дугаар улирлын мэдээллийг "үгүй" гэж оруулсан, оны эцэст үүссэн 42.3 сая төгрөгийн авлага, 21.6 сая төгрөгийн өглөг үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг байршуулаагүй байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 6.8.1-д заасныг мөрдөж төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан аливаа шийдвэрийг тухай бүр мэдээлж, хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Буянт сумын Эрүүл мэндийн төв	1	63.9								1	63.9